



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДИАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

**Тендерийн үнэлгээний хороо
байгуулах тухай**

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47 –р зүйлийн 47.1 заалт, ЭМСайдын 2018 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн А/416 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1.Сангийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Зураг төслийн ажлын жагсаалт батлах” тухай 177 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Сүрьеэгийн эмнэлгийн цогцолбор байгууллагын зураг төсвийн зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга	Г.Базархүрэл	ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	А.Шинэхүү	Эдийн засагч
Гишүүд:	Д.Энхмандах	СТСА-ны дарга
	П.Элбэгбаяр	ААХҮА-ны дарга
	Р.Дорждэрэм	Сүрьеэгийн их эмч
	Г.Сүрэнханд	Эмнэлгийн эрүүл ахуйн институт
	Д.Тогооням	Монголын барилагчдын нэгдсэн холбоо

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах хүртлэх бүх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг тендерийн үнэлгээний хорооны дарга / Г.Базархүрэл / -д даалгасугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгүүдийг эмхлэн цэгцэлж архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / А.Шинэхүү /-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ

My Documents\ATushaal2018.doc